



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 02 дугаар сарын 21 өдөр

Дугаар 11

Хэрлэн сум

Аймгийн Онцгой комиссын XI хуралдааныг 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 17:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 27 гишүүд оролцохоос 23 гишүүнтэй 86 % ирцтэй хуралдав.

Хурлыг аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын орлогч дарга Ч.Ганбат даргалж холбогдох үүрэг, даалгаврыг өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, нөхцөл байдлын талаар Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаагийн мэдээллийг сонслоо.

2. Хот, аймаг, сум хоорондын автотээврийн хөдөлгөөнийг хязгаарлах тухай хэлэлцэв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Бүсийн төв-аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах, Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг, Хэрлэн сумын орлогч дарга, Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир, Хөлөнбуйр, Булган сумын Засаг дарга нарт:

1. Улсын Онцгой комиссын 5 дугаар хуралдааны шийдвэр, аймгийн Онцгой комиссын гишүүд, мэргэжлийн байгууллагуудын саналыг үндэслэн Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор Хаврын тэргүүн сарын Шинийн нэгнээс гуравны өдрүүд, мөн өдрүүдийн өмнөх дараах өдрүүд буюу 2020 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 08:00 цагаас 2020 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 08:00 цаг хүртэл түр хугацаагаар нийслэл, бусад хотоос Дорнод аймгийн төв Чойбалсан хот руу орох, мөн Чойбалсан хотоос нийслэл, бусад хот хоорондын чиглэлд зорчигч тээврийн болон хувийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зогсоохыг,

2. Сумдын Онцгой комиссын саналын дагуу дээрх өдрүүдэд сумд хоорондын, аймгийн төв Хэрлэн сумаас бусад сумд руу зорчих, сумдаас аймгийн

төв Хэрлэн сум руу ирэх зорчигч тээврийн болон хувийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлахыг;

3.Хэрлэн суманд байнгын хяналтын цэг 3, хөдөлгөөнт эргүүл 3, Хөлөнбуйр суманд хөдөлгөөнт эргүүл 1, Булган суманд хөдөлгөөнт эргүүл 1, нийт 8 цэгт гарах, орох чиглэлийн авто замуудад хяналтын цэг, эргүүл гаргах хуваарь, шаардагдах зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлүүлэхийг;


4.Хяналтын цэг, хөдөлгөөнт эргүүлийн үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүн, автомашины бэлэн байдлыг хангаж, зорчигч тээврийн хөдөлгөөнийг хориглох, хязгаарлах, Хаврын тэргүүн сарын Шинийн нэгний өглөөний нар харах зорилгоор уул, овоонд очиж олон хүний бөөгнөрөл үүсгэхгүй байхад хяналт тавьж ажиллахыг;

5.Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас (ар гэрийн гачигдал, эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээ, албан томилолт, ажлын зайлшгүй шаардлага гэх мэт) хот, аймаг, сум хооронд зорчих төрийн албан хаагч болон иргэдийн нотлох баримтыг үндэслэн хүндрэл, чирэгдэл учруулахгүйгээр нэвтрүүлэхийг;

Бүсийн төв-аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах, аймгийн Засаг даргын Тамгын газрын Олон нийттэй харилцах албаны дарга Э.Батболдод

1.Хот, аймаг, сумын автотээврийн хөдөлгөөнийг түр хугацаагаар хориглох, хязгаарласан тухай мэдээллийг олон нийтэд мэдээллэх ажиллахыг;

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ, ОНЦГОЙ КОМИССЫН  
ОРЛОГЧ ДАРГА  Ч.ГАНБАТ

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА, ДЭД ХУРАНДАА  Д.БАТТУЛГА

